



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 1/13

Хужирт сум

Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.1.6 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.

2. Дээрх хугацаанд хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байх талаар иргэд, уяачдад сурталчлан хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Д.Давга), Цагдаагийн тасаг (Э.Баатарлхагва), "Хужирт ажнай" морин спорт уяачдын холбоо (Т.Баярмөнх)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.



ДАРГА

Д.БАТБАЯР

622401025
D:Alban bichig,Zahiramj 2023